



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/Ч

Улаанбаатар хот

▮ Багануур, Налайх, Багахангай дүүргийн ▮
Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн
дэргэдэх бичил, бизнес эрхлэгчдийн хамтарсан сургалт,
туршлага солилцох “Хамтын хөгжил III” арга
хэмжээнд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багануур дүүрэгт 2023 оны 03 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд зохион байгуулагдах Багануур, Багахангай, Налайх, дүүргийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн дэргэдэх бичил, бизнес эрхлэгчдийн хамтарсан сургалт, туршлага солилцох “Хамтын хөгжил III” арга хэмжээнд бичил, бизнес эрхлэгчдийг оролцуулсугай.

2.Арга хэмжээнд оролцох бичил, бизнес эрхлэгчдийн нэрсийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээг чанартай зохион байгуулж бичил, бизнес эрхлэгчдийн оролцоог ханган ажиллахыг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв (М.Өсөхдэлгэр)-д үүрэг болгосугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 1,653,200 (Нэг сая зургаан зуун тавин гурван мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL/2023 он ажил/захирамж

1123000135

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 24 -ны өдрийн 1742 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



БАГАНУУР, НАЛАЙХ, БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЖИЖИГ ДУНД, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВИЙН
ДЭРГЭДЭХ БИЧИЛ, БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ХАМТАРСАН
СУРГАЛТ, ТУРШЛАГА СОЛИЛЦОХ “ХАМТЫН ХӨГЖИЛ III”
АРГА ХЭМЖЭЭНИЙ ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Барааны материалын нэр	Хэмжих нэгж	Хүний тоо	Тоо ширхэг (1өдөрт)	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Багшийн хөлс		1		500,000	500,000
2	Аннос	М2		15	15,000	225,000
3	Шатахуун	л	-	90	2,380	214,200
4	Санхүүгийн боловсрол олгох гарын авлага (3 төрлийн)	ш	20	60	4,500	270,000
5	Дэвтэр	ш	20	20	8,500	170,000
6	Бал	ш	20	20	1,200	24,000
7	Хавтас	ш	20	20	2,500	50,000
8	Бичгийн цаас	ш	20	3	20,000	60,000
9	Black chart	ш	20	4	35,000	140,000
	Нийт дүн					1,653,200